



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО  
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/32/25

Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Жуулчин тээврийн зөвшөөрөл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.



**Б.ЗОЛБАДРАЛ**



*Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо (НЭЗХЭ)-ны  
Удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 17-ны  
өдрийн хурлын А/32/25 дугаар тогтоолын хавсралт*

## **ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээд (цаашид “НЭЗХЭ” гэх) Аялал жуулчлалын тухай хууль, Автотээврийн тухай хууль, НЭЗХЭ-ноос аялал жуулчлалын зорилгоор ашиглагдаж буй тээврийн хэрэгсэлд “ЖУУЛЧИН” гэх таних тэмдгийг (Цаашид “Жуулчин наалт” гэх) олгох, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журам нь тээврийн хэрэгслээр жуулчин тээвэрлэгч этгээдүүдийн үйл ажиллагааг ил тод, хяналттай, аюулгүй байлгах, жуулчин тээвэрлэгчийн эрх ашгийг хамгаалах зорилготой.

1.3. Энэхүү журмын дагуу НЭЗХЭ нь Аялал жуулчлалын тухай хуулийн 4.1.13 дахь заалтыг үндэслэн бартаа саад туулах чадамжтай авто тээврийн хэрэгслийг жуулчин өөрийн хүслээр сонгож байгаа тохиолдолд тухайн тээврийн хэрэгсэлд энэхүү журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг үндэслэн жуулчин тээврийн наалт олгоно.

1.4. Баталгаажуулалтын байгууллага нь Авто тээврийн үндэсний төвийн зохих шаардлага хангасан, сургалтад хамрагдсан, үзлэг оношилгоонд орж, тэнцсэн тээврийн хэрэгслийн бичиг баримт болон энэхүү журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримт бичгийг үндэслэн баталгаажуулалт хийх бөгөөд дүгнэлтээ НЭЗХЭ хүргүүлнэ.

### **ХОЁР. ЖУУЛЧИН НААЛТЫГ ОЛГОХ ЖУРАМ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. “Жуулчин” наалтыг дараах шаардлагыг хангасан тээврийн хэрэгсэлд олгоно:

2.1.1. Аялал жуулчлалын тухай хуулийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь хэсэгт заасан тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагатай тухай жилийн жуулчин тээврийн үйлчилгээ үзүүлэх гэрээтэй байх;

2.1.2. Авто тээврийн үндэсний төвийн албан ёсны сургалтад хамрагдсан байх;

2.1.3. Тухайн тээврийн хэрэгсэл нь хүсэлт гаргах өдрөөс 45-аас ихгүй хоногийн өмнө авто тээврийн үзлэг, оношилгоонд орж, тэнцсэн байх.

2.2. НЭЗХЭ нь зөвхөн дараах тээврийн хэрэгсэлд жуулчин наалтыг олгоно:

2.2.1. Зүүн хүрдтэй, Д ангиллын, 2010-2012 онд үйлдвэрлэгдсэн, minibus буюу бага оврын автобус /Уаз Фургон, Starex гэх мэт/;



2.2.2.Баруун хүрдтэй, Д ангиллын, 15 хүртэлх хүний суудалтай, minibus буюу бага оврын автобус /Hiase гэх мэт/;

2.2.3.Зүүн ба баруун хүрдтэй, В ангиллын, minivan төрлийн тээврийн хэрэгсэл /Delica, Alphard гэх мэт/;

2.2.4.Зүүн ба баруун хүрдтэй, В ангиллын, SUV 4x4 төрлийн тээврийн хэрэгсэл /LC 4.70, LC 5.70, LC 200, NP Y61, Y62 гэх мэт/;

2.3.Жуулчин наалтыг эзэмших тээврийн хэрэгслийн жолооч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1.тухайн ангиллын жолоодох эрхийн хүчинтэй үнэмлэхтэй байх

2.3.2.мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй байх

2.3.3.жолоочийн хариуцлагын даатгалтай байх

2.3.4.авто тээврийн даатгалтай байх

2.3.5.Аялал жуулчлалын тухай хуулийн 26.2-т заасан ёс зүйн дүрмийг зөрчөөгүй байх;

2.4.Энэхүү журмын 2.1 болон 2.3-т заасан баримт бичгийг Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны жуулчин тээвэр хариуцсан салбар холбоонд бичгээр болон цахимаар хүргүүлсэн өдрөөс хойш НЭЗХЭ-ийн Хууль эрх зүй, стандартын чиг үүргийн хороо ямар нэг бичиг баримтын, ёс зүйн зөрчилгүй тохиолдолд дүгнэлт гаргаж ажлын 14 хоногийн дотор жуулчин наалтыг олгож, бүртгэлд хамруулна.

### **ГУРАВ.БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГА СОНГОН ШАЛГАРУУЛАХ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

3.1.Жуулчин наалтыг үйлчилгээндээ ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд нийцэж байгаа эсэхийг хянан баталгаажуулах албан ёсны баталгаажуулалтын байгууллагыг НЭЗХЭ нээлттэй зар тавьж сонгон шалгаруулах ба тухайн байгууллага нь энэхүү журам, тус байгууллагатай байгуулсан гэрээнд заасан эрх болон үүрэг хүлээнэ.

3.2.НЭЗХЭ дүрэм, журмын хүрээнд НЭЗХЭ ажлын алба сонгон шалгаруулалтын зарыг шаардлагын хамт олон нийтийн сүлжээнд болон өдөр тутмын сонинд зар тавьж мэдээлнэ.

3.3.Сонгон шалгаруулалтын зар тавьсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шалгаруулалтад оролцогчдоос шаардсан бүрдүүлэх бичиг баримт, мэдээллийг info@mto.mn мэйл хаягаар илгээнэ.

3.4.Баталгаажуулалтын байгууллага нь энэхүү журамд заасан бичиг баримтад үндэслэн баталгаажуулалт явуулах бөгөөд баталгаажуулалт хийсэн тээврийн хэрэгслийн зөрчилд хариуцлага хүлээхгүй эрхтэй.

### **ДӨРӨВ. ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛЖ БАЙГАА ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ**



4.1.Жуулчин тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэн дараах эрхтэй:

4.1.1.жуулчин наалтыг өөрийн эзэмшиж буй тээврийн хэрэгсэлд чөлөөтэй байршуулах, ашиглах;

4.1.2.жуулчин наалттай холбоотой дэмжлэг, туслалцаа, арга зүйн дэмжлэгийг НЭЗХЭ, түүний холбогдох салбар болон чиг үүргийн хорооноос хүсэх;

4.1.3.жуулчин тээвэртэй холбоотойгоор НЭЗХЭ, түүний холбогдох салбар болон чиг хорооноос зохион байгуулж буй уулзалт, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд оролцох;

4.1.4.жуулчин наалтыг ашиглан жуулчин тээврийн үйлчилгээг саадгүй үзүүлэх.

4.2.Жуулчин тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэн нь дараах үүрэгтэй:

4.2.1.Аялал жуулчлалын тухай хууль, Автотээврийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, журам, аргачлал, заавар, стандарт болон Аялал жуулчлалын салбарын ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах;

4.2.2.Улирал бүр НЭЗХЭ-ийн жуулчин тээвэр хариуцаж буй салбар холбооны үйл ажиллагаанд идэвхитэй оролцох;

4.2.3.Жуулчин наалттай холбоотой аливаа, хүндрэл, бэрхшээл болон бусад асуудлын талаар НЭЗХЭ болон холбогдох эрх бүхий төрийн байгууллагад даруй мэдээлэх.

### **ТАВ.НЭЗХЭ-ИЙН ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН САЛБАР ХОЛБООНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

5.1.НЭЗХЭ-ийн жуулчин тээврийн асуудал хариуцсан салбар холбоо нь дараах эрхтэй:

5.1.1.жуулчин наалтыг авах хүсэлтэй иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэх;

5.1.2.жуулчин наалтыг ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж байгаа эсэх, энэхүү журамд заасан шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэхэд өөрөө болон баталгаажуулалтын байгууллагаар дамжуулан хяналт тавих;

5.1.3.жуулчин наалтыг ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн болох нь тогтоогдвол жуулчин наалтыг хураан авах;

5.1.4.жуулчин наалтыг үйлчилгээндээ ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны мэдээллийг мэдээлэл цуглуулах, статистик бий болгох, холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргүүлэх зорилгоор авах, боловсруулах;

5.1.5.жуулчин тээвэр, жуулчин наалтын ашиглалтыг сайжруулах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, судлаачидтай хамтран ажиллах, тэдгээртэй уулзах зохион байгуулах.



5.2.НЭЗХЭ-ийн жуулчин тээврийн асуудал хариуцсан салбар холбоо нь дараах үүрэгтэй:

5.2.1.жуулчин наалтыг ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтлан ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлагатай асуудлаар мэдэгдэл, шаардлагыг тухай бүр хүргүүлэх, энэ талаарх мэдээллийг НЭЗХЭ-д тухай бүр хүргүүлэх;

5.2.2.жуулчин наалтыг ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, хүсэлт, гомдлыг шийдвэрлэж холбогдох хариуг 30 хоногийн дотор өгөх;

5.2.3.жуулчин наалтыг ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн тоон мэдээлэл, статистик болон холбогдох бусад судалгааг нэгтгэн боловсруулж НЭЗХЭ болон холбогдох бусад төрийн байгууллагад хүргүүлэх, тэдгээрийг нээлттэй байршуулах;

5.2.4.жуулчин наалтыг ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, хүсэлт, гомдлыг шийдвэрлэлт болон энэхүү журамтай холбоотой бусад мэдээллийг улирал тутам НЭЗХЭ-ийн Гүйцэтгэх захиралд хүргүүлж, Удирдах зөвлөлд танилцуулах.

### **ЗУРГАА.БУСАД**

6.1.Жуулчин тээвэр, жуулчин наалттай холбоотой энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Аялал жуулчлалын тухай хууль, Автотээврийн тухай хууль болон НЭЗХЭ-ийн дотоод дүрэм, журмаар зохицуулна.

6.2.Жуулчин тээвэр, жуулчин наалттай холбоотой энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцаатай холбоотой зохицуулалт нь энэхүү журмын 6.1-д заасан эрх зүйн актад байхгүй тохиолдолд жуулчин тээврийн асуудал хариуцсан салбар холбоо, Чиг үүргийн хороо, Гүйцэтгэх захирал, шаардлагатай тохиолдолд НЭЗХЭ-ийн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

